

Хөрөнгө оруулалтын хамгаалалт, дэмжлэг хариуцсан мэргэжилтэн, Баярсайхан Номин

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
1.1. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах; төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөрөнгө оруулалт, татах, дэмжих, хамгаалах, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;							
1	"Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэн болон шинээр байгуулах, сайжруулах санал боловсруулна.	Төслийн тоо /Тоо /	Засгийн газрын 2019 оны 93 дугаар тогтоолоор Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн загвар хэлэлцээрийг баталсан.	"Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэн болон шинээр байгуулах саналыг боловсруулсан байна. /3 хэлэлцээрийн төсөл/	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/71 дүгээр тушаалаар "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр" /BIT/-ийн төслийн асуудлаар хэлэлцээ хийх, эцэслэн тохиролцох үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Монгол Улсын Засгийн газар болон БНТУ-ын Засгийн газар хооронд Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг 1998.03.16-ны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар.	100%

					өдөр байгуулсан бөгөөд тус хэлэлцээрийг шинэчлэн байгуулах саналыг 2021.11.15 -ны өдөр болсон Монгол, Туркийн 3Г хоорондын хамтарсан хорооны IX хуралдаанаар шийдвэрлэсэн. Туркийн тал хэлэлцээрийн төслөө 2022 оны 02 дугаар сард ирүүлсэнд Монголын тал хариу хүргүүлж байсан. Туркийн тал Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалэх хэлэлцээрийн загвар /Model BIT/-ыг 2024 оны 08 дугаар шинэчлэн баталсан бөгөөд 12 дугаар сард монголын талд хүргүүлэн хэлэлцээг үргэлжлүүлэх саналыг тавьсан. Тус асуудлаар ажлын хэсгийн хурлыг 2025.01.28-ны өдөр зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдэд мэдээлэл өгсөн. Хэлэлцээрийн төслийн боломжит хувилбарыг айлын талд хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн Тайланд, Вьетнам, Энэтхэг улсуудтай хэлэлцээрийн төслийн талаар цахим уулзалт хийж, хэлэлцээг үргэлжлүүлэхээр ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
2	Улсын хөрөнгө оруулалтын	Хэрэгжилтийн явц, хувиар	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний	"Монгол Улсын 2025-2030 оны	Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн	1-р сар, 2-р сар,	100%

хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч, үнэлэх, сонгох, эрэмбэлэх, хянан баталгаажуулах, бодлогын бичиг баримтыг эцэслэн боловсруулна.		удирдлагын тухай хууль батлагдсан.	хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг боловсруулж, батлуулсан байна. /100 хувь/	үндсэн чиглэлийг боловсруулах ажлын хүрээнд "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг боловсруулахаар ажиллаж байна. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт санал авахаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04 сарын 04-ны өдрийн 01/885 дугаартай албан бичгийг бүх сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарт хүргүүлсэн. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд нийт яамд болон Нийслэлийн засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр хариуцах албан хаагчдад 2025 оны 04 сарын 11-ны өдөр цахим системийн танилцуулга, ашиглах заавар, чиглэл өгөх сургалтыг зохион байгуулан ажилласан. Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /www.invest.gov.mn/-ээр дамжуулан УХОХ-т тусгах саналыг 2025 оны 8 дугаар сар хүртэл хүлээн авахаар төлөвлөсөн. Одосгийн байдлаар нийт 200 гаруй төслийн саналыг хүлээн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
---	--	------------------------------------	--	---	---	--

					авсан ба ирүүлсэн саналуудын чанар болон иж бүрдлийг шалгах ажил хийгдэж байна.		
3	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх саналыг хүлээн авч, эрэмбэлэх, тодорхойлох ажлыг зохион байгуулна.	Хэрэгжилтийн явц, хувиар	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2-р хавсралтын IV.1.4.1-д Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад хэрэгжүүлэхээр тусгагдаж батлагдсан.	Төсвийн хөрөнгө оруулалтаар техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх төсөл, арга хэмжээний жагсаалт батлагдсан байна. /100 хувь/	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдсан бөгөөд тус хуульд Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын багцад "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл, хангалт /Бүсүүдэд/ төсөл, арга хэмжээ тусгагдсан. Үүний хүрээнд бүх ТӨЗ болон 21 аймгийн ЗД нараас санал авсан бөгөөд 900 гаруй тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ТЭЗҮ, зураг төсөл хийлгэх төсөл, арга хэмжээний мэдээллийг авч, нэгтгэсэн бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн төслийн саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт туссан байдал, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, санхүүжилтийн эх үүсвэрийг хувийн хэвшлээр болон бусад эх үүсвэрээс санхүүжих боломж зэрэг үндсэн шалгуураас гадна бусад төсөвт өртөг, урсгал зардал нэмэгдүүлэх эсэх;	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					газрын асуудлыг харгалзан үнэлж эрэмбэлэн, сонгон шалгаруулалт хийгдэж сонгогдсон төслүүдийн жагсаалтыг Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/32, А/44, А/58 дугаар тушаалаар эцэслэн баталж жагсаалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт тухай бүр албан бичгээр тус тус хүргүүлсэн. 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт батлагдсан төслийн 81 хувь буюу 32 төслийн гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан байна. Үлдсэн төслийн худалдан авах ажиллагаа хэвийн үргэлжилж байна.		
4	Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төслийн хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийх, бэлэн байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар		Тухай бүр холбогдох арга хэмжээг авч, зохион байгуулсан байна. /100 хувь/	Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад туссан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Бүсүүдэд/ төсөл, арга хэмжээний багц хөрөнгө оруулалтын зардлаас УХЖТ-ний 2.1.1.4. Хавдар судлалын Үндэсний төв-II байгуулах, 1.5.1.2.Бүсчилсэн хөгжлийн зорилт, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан КООСЭН сургалтын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хөтөлбөрийг политехник коллежүүдэд үе шаттай нэвтрүүлэх. 2.15.1.2.Байгалийн түүхийн шинэ музейн барилга барих. 4.7.4.1.Цүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах МОН-22 гэх мэт зарим төсөл арга хэмжээний бэлэн байдлыг хангахаар батлагдсан төсөвт өртгийн хүрээнд шийдвэрлэсэн. Мөн 2025 онд Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын УЦС-ын төслийн БНХАУ-ын талтай зээлийн хэлэлцээрийг эцэслэн байгуулсан. Мөн БНХАУ-тай холбогдох хил холболтын төмөр зам болох "Гашуунсухайт-Ганцмод" төслийг эрчимжүүлэх, гэрээ хэлэлцээрийг байгуулах ажлын хэсэгт орж ажилласан ба бусад хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Мөн БНФУ-ын "Орано майнинг" ХХК-тай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээг бсловсруулах ажлын хэсэгт гэрээг байгуулахад шаардлагатай судалгаа, мэдээллийг тухай бүр болговсруулан ажилласан.		
5	Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын	Мэдээлэл сурталчилгаанд хамрагдах аж ахуйн нэгжийн тооны өсөлт,		Хувийн хэвшилд нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаагаар	2025 оны 3 дугаар сарын 13-ны өдөр "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум"-ыг зохион байгуулж, дотоодын болон гадаадын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар,	100%

байгууллагаас шаардах Комплаенсын шаардлагыг хангах зорилгоор "Комплаенсын менежментийн тогтолцоо ISO 37301" стандартыг хувийн хэвшилд нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаагаар хангана.	хувиар		хангасан байна. /100 хувь/	хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын 200 гаруй төлөөлөл оролцсоор Форумын үеэр төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин, бизнесийн орчны хууль, дүрэм, журам, стандарт, гэрээ, хувийн хэвшлийн бодлого, ёс зүйн асуудлыг хэлэлцэв. Мөн 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл"-ийг олон нийт болон оролцогч талуудтай хэлэлцэх зорилгоор ээлжит хэлэлцүүлгийг зохион байгуулж, олон улсын байгууллага, хөгжлийн түнш байгууллага, гадаад улсуудаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, хөрөнгө оруулагчдын төлөөлөл бүхий 130 гаруй хүн оролцсон. Хэлэлцүүлгийн үеэр Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын орчин, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг нээлттэй хэлэлцэж, бизнесийн орчны хууль, дүрэм, журам, стандарт, гэрээ, хувийн хэвшлийн бодлого, ёс зүйн асуудлыг хөндөн ярилцсан. Эдгээр арга хэмжээ нь олон улсын хөрөнгө оруулагчдын	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
---	---------------	--	---------------------------------------	--	---	--

					итгэлийг Нэмэгдүүлэх, Монгол Улсад комплаенсын соёлыг төлөвшүүлэх, улмаар ISO 37301 стандартыг хувийн хэвшилд нэвтрүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх юм. Хавсралт: 1 файл		
1.2. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хөрөнгө оруулалтын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулалтыг татах, хөгжлийн төслүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах ажлыг уялдуулан зохион байгуулах, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулж төслийн санхүүжилтийн төлөвлөлт, эдийн засаг, санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх, бэлэн байдал хангагдсан төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;							
6	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших зөвшөөрөл олгох асуудлыг судалж, шийдвэрлэх, үйл	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, хувиар		Тухай бүр холбогдох арга хэмжээг авч, зохион байгуулсан байна. /100 хувь/	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу БНФУ-ын "Орано майнинг" ХХК-тай байгуулах. Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг судлан хэлэлцэж, эцэслэн Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ерөнхий сайдын 2024 оны 27 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны 140 дугаар тушаалын хавсралтаар байгуулагдсан Эдийн засаг, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажлын дэд хэсэгт оролцож, гэрээг байгуулахад шаардлагатай судалгаа, мэдээллийг тухай бүр боловсруулан ажилласан. Тус Монгол Улсын Засгийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	ажиллагаанд хяналт тавина.				газар болон Орано Майнинг компани хоорондын Хөрөнгө оруулалтын гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ олгуулах хүсэлтэд дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байнгын болон байнгын бус нийт 17 гишүүнтэй байгуулахаар төлөвлөж байгаа ба зөвлөлийн ажиллах журмын төслийг боловсруулсан. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох асуудлаар тухай бүр хүсэлт гаргасан байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл өгсөн.		
7.	Хөгжлийн бодлогын баримт бичигтэй гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийх арга хэмжээг уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудын хамт	Хэрэгжилтийн явц, хувиар		Тухай бүр холбогдох арга хэмжээг авч, зохион байгуулсан байна. /100 хувь/	Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг 2025 онд багтаан боловсруулахаар ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Улсын 2026-2030 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахдаа салбар яамдаас санал авч ажиллаж байна. Ирүүлсэн саналуудыг үнэлж, эрэмбэлэн боловсруулахдаа гадаадын зээл, тусламжаар хэрэгжих	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

тодорхойдох, холбогдох гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.				боломжтой төслүүдийг тодорхойлон салбар яам, сангийн яам болон ОУБайгууллагуудтай хамтран боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна. "Шинэ сэргэлтийн бодлого, ЗГҮАХ 2024-2028-т туссан төслүүдийн хүрээнд гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлж гаргасан. Тус ажлын хүрээнд салбар яамд болон ОУБайгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох ажлыг тухай бүр зохион байгуулж, санал хүргүүлж ажилласан. Мөн Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Дэлхийн банк болон АНУ, БНСУ, Япон улсын төлөөлөлтэй уулзалтыг зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөөг ярилцан, тохиролцож зээл тусламжийн эх үүсвэрээр одоо хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний талаарх санал солилцсон.	
1.3. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийг эрэмбэлэх, хянан баталгаажуулах, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, төслүүдийг нэгдсэн удирдлагаар хангах, төслийн оролцогч талуудтай хамтран ажиллаж зохион байгуулах, хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар					

хангах, эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцох, хэрэгжилтэд хяналт тавих;							
8	Бэлэн байдал хангагдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, үйлдвэржилт, дэд бүтэц, хөгжлийн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого тодорхойлно.	Хэрэгжилтийн явц, хувиар	Мега төслүүдийг хариуцсан салбар яамд болон холбогдох байгууллагуудтай уулзалтыг зохион байгуулж төслүүдийн төлөвлөлт, мониторинг, үнэлгээ болон төслүүдийг хэрэгжүүлэхэд учирч буй саад бэрхшээлүүдийн талаар мэдээлэл солилцож арга зүйн дэмжлэг үзүүлсэн.	Хөгжлийн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэр, нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, гэрээ хэлэлцээр байгуулах бэлтгэл ажил хангагдсан байна. /100 хувь/	Тэргүүлэх ач холбогдол бүхий "Шинэ сэргэлтийн бодлого, ЗГҮАХ 2024-2028-т туссан бэлэн байдал хангагдсан хөгжлийн төслүүдийн эх үүсвэрт шийдвэрлэх ажлыг тухай бүр салбар яамд болон ОУБайгуулаагуудтай хамтран ажилласан. 2025 онд Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын УЦС-ын төслийн БНХАУ-ын талтай зээлийн хэлэлцээрийг эцэслэн байгуулсан. Говийн бүсийн ус хангамжийг сайжруулах "Орхон-Онги" төслийн бэлэн байдлыг хангуулж БОУАӨЯамтай хамтарсан ажлын хэсэг байгуулагдан төслийг ойрын хугацаанд эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ажилд оролцон ажилласан. Мөн БНХАУ-тай холбогдох хил холболтын төмөр зам болох ""Гашуунсухайт-Ганцмод"" ""Ханги-Мандал"" ""Шивээхүрэн-Сэхээ"" зэрэг төслүүдийг эрчимжүүлэх, гэрээ хэлэлцээрийг байгуулах ажлын хэсэгт орж ажилласан ба бусад хөгжлийн томдохон төслүүдийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд АХБ-тай хамтран ажиллаж	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					байна. Мөн Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Дэлхийн банк болон АНУ, БНСУ, Япон улсын төлөөлөлтэй уулзалтыг зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөөг ярилцан, тохиролцож зээл тусламжийн эх үүсвэрээр одоо хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний талаарх санал солилцсон. Мөн Дорноговь аймагт Газрын төс боловсруулах цогцолборын нэмэлт зээлийн хэлэлцээрийг байгуулах ажилд оролцон ажилласан. Монгол Францын хамтарсан ураны төслийн ажлыг хэсэгт орж ажилласан. Зүрх судасны үндэсний төвийн санхүүжилтийг шийдвэрлэхээр ЕСБХБ-д хүсэлт хүргүүлсэн. Мөн зарим тоног төхөөрөмжийг Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ ЦДАШ-ын санхүүжилтийн шийдвэрлэх ажлын хүрээнд ЕСБХБ-тай зээлийн хэлэлцээрийг байгуулсан.		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг-даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Ажлын чиг үүрэгтэй холбоотой сургалт, хөтөлбөрт тухай бүр хамрагдсан байх	Сургалт, хөтөлбөрт тухай бүр хамрагдсан байна. /100 хувь/		Сургалт, хөтөлбөрт хамрагдсан байх /Хувь/	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин болон Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар сурталчлах, танилцуулах, санал солилцож, хэлэлцэх зорилго бүхий "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум" 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд тус форумд гадаадын болон дотоодын хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид мөн оролцсон. Монгол Улсад ногоон төсөл хөгжүүлэхэд оролцогч талуудын мэдлэгийг бэхжүүлэх хүрээнд ногоон төслийг сонгох, салбаруудад төслийг шалгаруулах, эрэмбэлэх, худалдан авах чиглэлээр ойлголт өгөх зорилготой 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан "Монгол Улсын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					ногоон санхүүгийн хөгжил" арга хэмжээнд оролцсон.		
2	Хувь хүний хөгжил болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлэх	Хувь хүний хөгжил болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	-	Хувь хүний хөгжил болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна. /100%/	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэд захирал, доктор Н.Алтанзул "Ажил, амьдралын тэнцвэр" сэдэвт сургалт 2025.04.25 Бүгд Найрамдах Казахстан Улсын Алматы хотноо зохион байгуулагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын менежментийн туршлагыг бэхжүүлэх нь" сэдэвт сургалт 2025.05.12-16	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3	Монгол бичгийн мэдлэгийн түвшнийг дээшлүүлсэн байх	Сургалтад хамрагдсан байх	-	Сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн байна.	Монгол Улсын Засгийн газар 2020 онд гаргасан бодлого шийдвэрийн хүрээнд Монгол бичгийг 2025 оноос төрийн албан ёсны хэрэгцээнд бүрэн нэвтрүүлэх зорилт дэвшүүлсэн. Үүний хүрээнд Монгол бичгийн мэдлэгээ нэмэгдүүлэх зорилгоор тухай бүр сургалтад хамрагдаж байсан бөгөөд одоогоор Microsoft Word программд ашиглахаар суралцаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөрөнгө оруулалтын хамгаалалт, дэмжлэг хариуцсан мэргэжилтэн, Баярсайхан Номин /...../

Огноо:

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Бат-Ирээдүй Анар /...../

Огноо: